

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Газар тариалангийн үйлдвэрлэл, техник, технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Баттөмөр Оюунтунгалаг

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
1.1. Тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, газар тариалангийн хүрсэн түвшинг тогтворжуулан хөгжүүлнэ							
1	Газар тариалангийн ажлыг технологийн зохистой хугацаанд хийж гүйцэтгэх ажлыг зохион байгуулах.	Тариалсан талбай, хураан авсан ургацын хэмжээгээр	Талбай: Үр тариа 3904 га, малын тэжээл 287 га, төмс 145 га, хүнсний ногоо 455 га, Ургац: Үр тариа 10752 тн, төмс 1628 тн, хүнсний ногоо 9520 тн, тэжээлийн ургамал 1122 тн	Намрын ургац хураалтын ажлыг технологийн хугацаанд чанартай гүйцэтгэх ажлыг зохион байгуулах.	Аймгийн хэмжээнд хаврын тариалалт, ургац хураалтын ажлыг технологийн хугацаанд чанартай гүйцэтгэх ажлыг шуурхай зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын 2024 оны А/293, А/641 дугаар захирамжаар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан. Газар тариалангийн үйлдвэрлэлийн ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1.Жаргалант сумын Агро үйлчилгээний төв нь 124 иргэний 102.2 га талбайг	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

154

				хагалах, 2 иргэний 2.3 га талбайд бууц цацах, 66 иргэний 38 га талбайд төмс тарих, 22 иргэний 21 га талбайд хүнсний ногоо тарих, 47 иргэний 28 га талбайн хөрс бутлах, 3 иргэний 6 га талбайд ургамал хамгааллын бодис цацах, 6 иргэний 12 га талбайд ногоон тэжээл тариалах нийт давхардсан тоогоор 270 иргэний 209.5 га талбайд үйлчилгээ үзүүлсэн бол ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэх ажилд гарч иргэн, аж ахуйн нэгжийн захиалгаар өвс хадах, тармах, хаман боох, төмс хураахад давхардсан тоогоор 343 иргэний 335.3 га талбайд 4 төрлийн үйлчилгээг үзүүллээ. Энэ онд аймгийн хэмжээнд үр тариа 3841 га-д үүнээс 3723 га-д улаанбуудай, 118 га-д бусад үр тариа (вандуй, овьёос), 280 га-д малын тэжээл, 832 га-д тосны ургамал, 167 га-д төмс, 474 га-д хүнсний ногоо, нийт 5594 га-д тариалалт хийн 3841 га-аас 10097 тонн үр тариа, 167 га-аас 1941 тонн төмс, 474 га-аас 12149 тонн хүнсний ногоо 832 га-аас 284 тонн тосны ургамал,		
--	--	--	--	---	--	--

					280 га-аас 1294 тонн тэжээлийн ургамал тус тус хураан авсан. Энэ нь аймгийн хүн амын хэрэгцээт улаанбуудайг 100 хувь, төмсийг 51 хувь, хүнсний ногоог 100 хувь орон нутгийн үйлдвэрлэлээр хангаж байна.		
2	Өрхийн тариалалтыг дэмжих хөтөлбөрийг хэрэгжилтийг ханган ажиллах	Хамрагдсан аж ахуйн нэгж, өрхийн тоо	Баян-Өндөр сумын 26 багийн 500 өрх хамрагдсан	Хөтөлбөрийн хүрээнд тариалсан талбай, хураан авсан ургацын мэдээ, үр дүнг холбогдох газруудад тайлагнасан байна.	Орхон аймаг, Эрдэнэт хотыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан "Өрхийн тариалалтыг дэмжих хөтөлбөр", аймгийн Засаг даргын 2022 оны А/89 дүгээр захирамжаар батлагдсан "Төмс, хүнсний ногооны үр, хүлэмжийг дэмжлэгээр олгох журам"-ыг хэрэгжүүлэх зорилгоор Хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах тухай аймгийн Засаг даргын 2024 оны А/72 дугаар захирамжийг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Захирамжийн хүрээнд төмс, хүнсний ногооны үрийг хөнгөлөлттэй	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 9-р сар, 10-р сар	100%

					нөхцөлөөр олгох ажлыг зохион байгуулахаар 70.000.000 /дөчин сая/ төгрөгийг батлуулсан. Захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор Хүнс, хөдөө аж ахуйн газар нь Талын нуур ХХК-тай "Ажил гүйцэтгэх гэрээ"-г байгуулан, тус газар нь сургалт явуулах танхим болон техник хэрэгслээр ханган ажиллалаа. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлыг гэрээний хавсралтаар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан. Мөн Талын нуур ХХК-тай "Ажил гүйцэтгэх гэрээ байгуулахад хэлцэл хийн шийдвэрлэсэн. 1.Өрхийн тариалалтын дэмжих хөтөлбөрийн хүрээнд дараах үрийн дэмжлэгийг олгон ажилласан. Үүнд: 1. Жаргалант сумын 500 өрхийг хамруулан 135 кг 4 төрлийн хүнсний ногооны үр, 30 тн төмсний үр 2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны А/257 дугаар тушаалаар төмс, хүнсний ногооны үрийг 80 хувь хөнгөлсөнтэй холбогдуулан Орхон аймагт 7.5 тн үрийн		
--	--	--	--	--	---	--	--

					төмс, 5.9 тн 10 төрлийн 13.4 тн үр хуваарилсныг сумын Засаг даргын тамгын газартай хамтран тариаланчдад олгох ажлыг зохион байгуулсан. Үүний үр дүнд 120 га талбай хүнсний ногоо, 14 га төмс тарих үрийн дэмжлэг олгож, үрийн хэрэгцээний 30 хувийг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгосон.		
3	Тариалангийн эргэлтийн талбайг нэмэгдүүлэх	Нэмэгдсэн тариалангийн талбайн хэмжээ /га/	45,19	Тариалангийн талбайг нэмэгдүүлсэн байна.	Тариалангийн талбайн газрыг нэмэгдүүлэх зорилгоор Жаргалант сум 2024 онд тариалангийн зориулалтаар 62.8 га талбай шинээр олгохоор газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан. Баян-Өндөр сум хүлэмжийн аж ахуйн чиглэлээр 1.5 га, мод үржүүлгийн чиглэлээр 26 га газар иргэн, аж ахуйн нэгжид олгосон.	9-р сар	100%
4	Хүлэмж аж ахуйг дэмжин хөгжүүлэх	Хамгаалагдсан хөрсний ургацын хэмжээ /тн/	304 тн	Хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийг тайлан мэдээнд хамруулсан байна.	Хүлэмжийн аж ахуйг дэмжин хөгжүүлэх зорилгоор улсын төсвийн хөрөнгөөр 6*10 м харьцаатай хүлэмжийн техникийн тодорхойлолтыг холбогдох газарт хүргүүлснээр энэ онд улсын төсвийн хөрөнгөөр 100 ширхэг хүлэмжийг олгохоор шийдвэрлэсэн. Тус	4-р сар, 5-р сар, 8-р сар	100%

					хүлэмжийг тариаланчдад олгох ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Тус ажлын хүрээнд хүлэмж авах хүсэлтэй иргэдийн дунд хүлэмжийг гэрээгээр эзэмшүүлэх зорилгоор сонгон шалгаруулалтын зарыг явуулж материалыг Жаргалант сумын Засаг даргын тамгын газарт хүлээн авч Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын тушаалаар баталсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн нь төсөл сонгон шалгаруулан иргэдэд хүлэмж олгон гэрээ байгуулан ажилласан. Баян-Өндөр хүлэмжийн цогцолбор аж ахуй байгуулах 1.5 га газрыг олгон, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хашаажуулан, цахилгаан болон усны эх үүсвэрийг шийдвэрлэж улсын төсвийн хөрөнгөөр 120 м.кв талбай бүхий 26 ширхэг нийт 3120 м.кв хүлэмжийг бариж ашиглалтад оруулсан. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн зээлд 1 аж ахуйн нэгж өвлийн хүлэмжийн аж ахуйн чиглэлээр хамрагдсан. Төсөлд хамрагдснаар 140 м..кв өвлийн хүлэмж		
--	--	--	--	--	---	--	--

					баригдах боломжтой. Баян-Өндөр сумын 2 иргэн нийт 1129 м.кв өвлийн хүлэмж шинээр ашиглалтад оруулсныг дэмжин цахилгааны хөнгөлөлтөд хамрагдах 2024 онд шинээр нэмэгдсэн хүлэмжийн аж ахуйн судалгаанд хамруулан Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн.		
5	Тариалангийн газрын хөрсний төлөв байдал, чанарт тавих хяналтыг сайжруулах	Тариалангийн газрын хөрсний төлөв байдлын шинжилгээ өгсөн талбайн хэмжээ.га-аар	82,5	2000 га хүрсэн байна.	Тариалангийн газрын хөрсний төлөв байдал, чанарын хянан баталгааг 13 иргэн, 4 аж ахуйн нэгжийн эзэмшлийн 59 нэгж талбарын 3125 га талбайд хийж гүйцэтгэж зөвлөмж, арга зүйгээр хангасан. "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" УИХ-ын 36 дугаар тогтоолын Газар тариалангийн чиглэлийн е хэсэгт "Хөрсний шим тэжээлийн бодисын алдагдлыг нөхөх, ургацын чанар, хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор дотооддоо бордооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх" ажлын хүрээнд хөрсний үржил шимийг сайжруулж, ургацыг нэмэгдүүлэх зорилгоор бордоо хэрэглэсэн иргэн,	9-р сар	92%

					хуулийн этгээдэд татаас олгож байгааг тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч дэд сурталчилан таниулах ажлыг зохион байгуулсан. Үүний үр дүнд 4 аж ахуйн нэгж, 5 иргэн тус хөнгөлөлтөд хамрагдахаар Газар тариалангийн нэгдсэн системд хүсэлтээ илгээсэн.		
6	Стандартын шаардлага хангасан зоорийн аж ахуй байгуулахад дэмжин хөгжүүлэх	Шинээр баригдаж, сэргээн засварлаасан зоорины багтаамжаар /тонн/	500 тн	Зоорийн барилгын ажилд холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт тавин ажиллах,	Жаргалант суман орон нутгийн төсвийн хөрөнгөөр 500 тн багтаамжтай бүрэн механикжсан зоорины барилгын ажлыг хийж ашиглалтад хүлээн авч Жаргалант сумын өмчид бүртгэх ажлыг хийж гүйцэтгэсэн.	5-р сар, 9-р сар	100%
7	Тариалангийн талбайд ойн зурвас байгуулах	Тариалангийн талбайн ойн зурвасны хэмжээ	-	Тариалангийн талбайн ойн зурвас байгуулах ажлыг холбогдох мэргэжлийн байгууллага болон аж ахуй нэгж, иргэдтэй хамтран зохион байгуулах	Тариалангийн талбайг элэгдэл эвдрэлээс хамгаалах ажлын хүрээнд: Жаргалант сумын Бөөн бүргас, 36-р тоочигч төмс, хүнсний ногооны талбайн 18.6 км хашааг шинээр барьж ашиглалтад оруулан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас тариалангийн талбайн хашааны төмөр бетон шон 24000 ширхэгийг манай аймагт хуваарилсныг татан авч үр тарианы үйлдвэрлэл эрхлэгч 9 аж ахуйн нэгж, 3 иргэнд гэрээгээр	6-р сар, 10-р сар	100%

					эзэмшүүлсэн. Үүний үр дүнд нийт 9 аж ахуйн нэгж 254 иргэний эзэмшлийн 5153 га талбайг хашиж хамгаалсан. Тариалангийн талбайг хашаажуулснаар цаашид ойн зурвас байгуулах ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна. Хантөгөл хайлаас ХХК, Алтан үрслэг ХХК нь 10 га төмс, хүнсний ногооны талбайг хамгаалсан 300 урттай ойн зурвас байгуулсан.		
8	Жимс, жимсгэний талбай, хураан авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх	Тариалсан талбай, хураан авсан ургацын хэмжээ	43 тн ургац	Жимс, жимсгэний тариалсан талбай, хураан авсан ургацын мэдээг гарган холбогдох газар хүргүүлсэн байна	2024 онд аймгийн хэмжээнд үхрийн нүд 500 ширхэг буюу 0,4 га, бусад жимсний мод 120 ширхэг буюу 0,2 га талбай, нийт 0,7 га талбайд жимс, жимсгэний суулгац тариалж нийт 62 тн ургац хураан авсан.	5-р сар, 10-р сар	70%
9	Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийг чадавхижуулах сургалт зохион байгуулах	Сургалт зохион байгуулсан тоо	4	Сургалт зохион байгуулсан байна.	“Өрхийн тариалалтыг дэмжих хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг ханган ажиглах тухай аймгийн Засаг даргын 2024 оны А/72 дугаар захирамжийг батлуулан, Жаргалант сумын 500 өрхийн тариаланчдад “Газар тариалангийн үйлдвэрлэлийн цахим бүртгэлийн систем” болон “Тариалангийн үйлдвэрлэл	3-р сар, 4-р сар	100%

					эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журам"-ыг танилцуулж, төрөөс олгож буй урамшуулал, дэмжлэгт хамрагдахад системийг хэрхэн ашиглах, материалыг цахимаар бүрдүүлэх талаарх багц сургалтыг зохион байгуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 481 дүгээр тогтоолоор 2024 оныг "Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан "Хаврын тариалалт- Бүсчилсэн хөгжил 2024" тариаланчдын улсын зөвлөгөөнийг бүсчилсэн байдлаар зохион байгуулах тухай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 01/1368 дугаарт албан тоотойр ирүүлж, Хойд бүсийн тариаланчдын зөвлөгөөнийг Орхон аймагт 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулж, Хөвсгөл аймгийн 60 тариаланч, Булган аймаг 130		
--	--	--	--	--	---	--	--

					тариаланч, Орхон аймгийн 210 тариаланч нийт 400 тариаланч оролцсон. Орхон аймгийн Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Соёл, урлагийн цогцолборт зохион байгуулж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Салбарын хяналтын газар, Ургамал газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэн, Ургамал хамгаалал эрдэм шинжилгээний хүрээлэн, Хөдөө аж ахуйн Их сургууль, Хөдөө аж ахуйн корпорац ТӨХК зэрэг байгууллагын удирдлага, мэргэжилтнүүд оролцон тариаланчдад мэдээлэл өгч ажилласан.		
2.1. Газар тариалангийн салбарын хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг таниулах, үйлдвэрлэл эрхлэгчдийг мэргэжил арга зүйгээр хангах							
10	Plant.mofa.gov.mn системд бүртгүүлэхэд арга зүйгээр хангах, цахим урамшуулал болон төрөөс олгож буй урамшууллаас нийгмийн даатгалд хамрагдах боломжийг бүрдүүлэн ажиллах	Системд мэдээлэл оруулсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо, гарал үүсэлтэй бүтээгдэхүүний хэмжээ	plant.mofa.gov.mn цахим системд 30 аж ахуйн нэгж, 328 иргэнийг тариаланчаар бүртгэж тэдгээрийн 481 талбарын 5279.4 га талбайг баталгаажуулж 2022 оны ургацаас 175 удаагийн	Plant.mofa.gov.mn системд бүртгүүлэх ажлыг эрчимжүүлэн, арга зүйгээр ханган ажилласан байна.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Сангийн сайдын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/218/А/146 дугаар хамтарсан тушаал баталсан "Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн	4-р сар, 10-р сар, 11-р сар	100%

			урамшууллын хүсэлтийг цахимаар илгээснээр 900.0 сая төгрөгийн урамшуулалд хамрагдсан.		урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журам"-ын хэрэгжлтийг ханган ажиллаж байна. Үүний үр дүнд 2024 оны хаврын тариалалтын мэдээг Plant.mofa.gov.mn цахим системд оруулахад арга зүйгээр ханган ажилласан. Хөтөлбөрийн хүрээнд явуулсан сугалтын үр дүнд Жаргалант сумын хөтөлбөрт хамрагдсан өрхийн 46 хувь буюу 229 өрх нь газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэн plant.mofa.gov.mn цахим бүртгэлийн систем үйл ажиллагаагаа баталгаажуулан орон нутгийн зах зээлд өөрийн үйлдвэрлэсэн төмс, хүнсний ногоог нийлүүлснээр 900.0 гаруй сая төгрөгийн урамшуулалд хамрагдах боломж бүрдээд байна.		
11	Үрийн тариалангийн талбайд сортын хянан баталгаа хийж гүйцэтгэх,	Хянан баталгаан хамрагдсан таримлын төрөл, сорт, талбайн хэмжээ, нөөцөлсөн үрийн хэмжээ.	Сортын үрийн хянан баталгааг 4 аж ахуйн нэгж төмсний 1 сортын 20 га талбай, улаанбуудайн 5 сортын 2300 га талбайд хийж ирэх хаврын тариалалтад шаардлагатай 800	Хянан баталгааг хийж, үрийн нөөц бүрдүүлсэн байна.	Аймгийн хэмжээнд улаанбуудайн үр үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй 2 аж ахуйн нэгж, төмсний үр үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй 1 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Улаан буудайн үрийн нөөцийг бүрдүүлэх зорилгоор 2 аж ахуйн	8-р сар	100%

			тонн үрийн буудайг өөрийн үрэнд		нэгжийн 1733 га талбайд 7 төрлийн сортын үрийн хянан баталгааг хийж гүйцэтгэсэн. Улсын үрийн нөөц: Хөдөө аж ахуйн корпораци ТӨХК-д үрийн буудай 4828 тн, өөрийн үрийн нөөцөд 730 тн нийт 5558 тн стандартын шаардлага хангасан үрийн буудай үйлдвэрлэсэн байна.		
3.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах							
12	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх				Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн газар тариалангийн салбарт хэрэгжиж буй хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, төсөл хөтөлбөрийн тайлан мэдээг гарган холбогдох газарт хүргүүлэн ажилласан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
13	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс				2023 оны газар тариалангийн салбарын чиглэлээр хийгдсэн ажлын	1-р сар, 2-р сар, 3-р сар,	100%

төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх				тайлан болон холбогдох бусад материалыг архивын нэгж болгон байгууллагын архив бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгч ажилласан. Мөн салбарын чиглэлээр иргэдээс ирүүлсэн сманал хүсэлт, гомдлыг тухай бүрт шийдвэрлэн хариуг өгч ажилласан.	4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
--	--	--	--	--	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь

1	2	3	4	5	6	7	
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Газар тариалангийн салбарын Зөвлөгөөн , сургалт арга хэмжээнд тогтмол хамрагдсан байна.	Сургалт арга хэмжээнд оролцсон байна.	2 удаагийн арга хэмжээ, 4 удаагийн сургалтад хамрагдсан.	Мэдлэг чадвар дээшилсэн байна.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Салбарын хяналтын газар, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Хүнсний ногооны үйлдвэрлэлийн эрх зүйн орчин, хүнсний аюулгүй байдал, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах” сэдэвт сургалт, хэлэлцүүлэгт хамрагдсан. Монгол Улсад шинжлэх ухааны үндэслэлтэй Жимс, жимсгэний салбар үүсэж хөгжсөний түүхт 70 жилийн ойг угтсан арга хэмжээний хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Жимс, жимсгэний тариаланд баримтлах хөдөө аж ахуйн зохистой дадал” сэдэвт сургалт, хэлэлцүүлэгт оролцсон Мөн Хойд бүсийн тариаланчдын зөвлөгөөнийг зохион байгуулсан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” төслөөс зохион байгуулсан “Газар тариалангийн салбар дахь технологи дамжуулалт” сэдэвт олон улсын онол-үйлдвэрлэлийн бага хуралд Газар тариалангийн үйлдвэрлэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн оролцсон. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн	3-р сар, 4-р сар, 5-р сар, 8-р сар, 11-р сар	100%

					төв, Орон нутгийн тогтвортой хөгжлийн төлөө холбоо хамтран аймгийн газар тариалангийн үйлдвэрлэл, техник технологи хариуцсан мэргэжилтнийг чадавхжуулах зорилгоор "Хамгаалагдсан хөрсний экстейншний сургагч багш бэлтгэх сургалтад хамрагдсан.		
--	--	--	--	--	---	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

Газар тариалангийн үйлдвэрлэл, техник, технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Баттөмөр Оюунтунгалаг

/.....*B. Oduf*...../

Огноо: ...*2024.12.05*...